

# “ХАР ЖАГСААЛТАД” ОРОХГҮЙН ТӨЛӨӨ ТӨР, ЗАСАГ ОЛОН АЖИЛ ХИЙЖ БАЙНА

Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлдог Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо (Financial Action Task Force буюу ФАТФ)-ноос Монгол Улсыг өөрийн хяналтын хоёрдахь шат (targeted review)-нд оруулахаар болсон байна. Энэ талаар Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны дарга Б.Төмөрбатаас сонирхлоо.

дээрх үзүүлэлтийн 15-д нь муу, 21-д нь дунд үнэлгээ авсан юм. Үндсэндээ бол 49 үзүүлэлтийн 36-д нь хангалтгүй дүн авсан гэсэн үг.

-Тэр 49 үзүүлэлтэнд чинь чухам юу юу ордог юм бэ?

-Зарим нэгийг нь дурдая. Санхүүгийн байгууллага нь харилцагчаа сайн мэдэхгүй байх, хөрөнгө хураах, битүүмжлэх тодорхой механизм байхгүй, өөрөөр хэлбэл энэ нь олон улсын стандартыг хангаагүй, терроризмыг санхүүжүүлэхийг эсэргүүцэх есөн

тагнуулын албаны үйл ажиллагаа жигдрээгүй зэрэг дутагдал манайд байсан юм. Тухайн үед санхүүгийн тагнуулын алба дөнгөж үүсээд, үйл ажиллагаа нь цэгцрээгүй байв. Мөн сэжигтэй мөнгөний гүйлгээг мэдээлэх тогтолцоо хөгжөөгүй байлаа. Энэ мэт олон юм хэлж болно.

-ФАТФ ийм шалгалт, үнэлгээг ямар хугацаанд хийдэг юм бэ?

-Эдний хийдэг шалгалт үнэлгээ тодорхой үе шаттай. Манай улсын хувьд анхныхыг нь 2007 онд хийсэн

хяналт шалгалт хийсэн юм. Энэ нь олон улсын зүгээс үзүүлсэн шахалттай холбоотой. 2008 онд дэлхий дахиныг санхүүгийн хямрал нөмөрснийг бүгд мэдэж байгаа байх. Энэ хямралын эсрэг авах арга хэмжээний хүрээнд 2009 оны дөрөвдүгээр сард хуралдсан “Их 20”-ийн /G-20/ Сангийн сайд нар улс орнуудын санхүүгийн тогтолцоог татварын болон бусад төрлийн гэмт хэргээс хамгаалах, ил тод байдлыг хангах, санхүүгийн мэдээллийг солилцох ажиллагааг сайжруулахтай холбогдуулж хамтран

эхэлсэн юм билээ. Одоогийн байдлаар 74 улс энэ хяналтад хамрагдаад байгаа бөгөөд Монгол Улс тэдний нэг нь.

-“Хар жагсаалт” гэж ФАТФ-д байдаг юм гэсэн. Түүнд одоо ямар орнууд бүртгэлтэй байна вэ? Манай улс түүнээс хэр хол байна вэ?

-Энэ жагсаалтад одоогоор Иран, Умард Солонгос ороод байна.

-Энэ жагсаалтад орсон орнуудад ямар аюул заналхийлдэг юм бэ?

-Санхүүгийн ямар нэг харилцаа тогтоохгүй байхыг дэлхийн санхүүгийн бүх байгууллагад ФАТФ зөвлөдөг. Энэ зөвлөмж заавал биелэх чадамжтай байдаг. Ийм оронтой гадаадын санхүүгийн аливаа байгууллага харилцахаа болино.

Мөнгөний ямарваа гуйвуулга, шилжүүлэг байхгүй болно. Уг жагсаалтад орсон орноос гадаадад зорчиж буй иргэд санхүүгийн үйлчилгээний аливаа карт ашиглах эрхгүй болно

-Тэгэхлээр ийм “хар жагсаалтад” улс орноо оруулчихгүйн тулд манай төр, засгаас аливаа арга хэмжээ авна биз дээ?

-Дээр өгүүлсэн дутагдлуудыг арилгах, өөрөөр хэлбэл ФАТФ-ын зөвлөмжид дурдсан заалтуудыг бүрэн биелүүлэх талаар манай төр засгаас холбогдох арга хэмжээг авч байна. Тухайлбал, дутагдлуудыг арилгах, үүний тулд холбогдох хэд хэдэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Энэ төсөл бэлэн болсон. Тэгэхлээр уг асуудлыг нэг тийш болгоход улс төрчдийн хүчин зүтгэл, хүсэл зориг ихээхэн үүрэгтэй байх нь. Мөн энэ асуудалтай холбоотойгоор хянан шалгах тогтолцоо нь орон тоогоо нэмэгдүүлнэ.

Тодорхой ажил хийх хугацаатай үүргийг манай улсад ФАТФ-аас өгсөн. Эдгээр үүргийн хугацаа янз бүр, тэгэхдээ 1-2 жилийн хугацаанд хэрэгжих ёстой. Энэ үүргийн төсөл одоо бидэнд ирээд байгаа. Төслөөс үзвэл биелүүлэхэд хүндрэлтэй зүйл ховор. Төсөлд бид саналаа өгөх эрхтэй. Албан ёсоор энэ үүрэг зургадугаар сард бидэнд ирнэ.

-ФАТФ гэж товчлон нэрлэдэг байгууллагын талаар эхлээд тодруулах нь зөв байх. Хэзээ байгуулагдсан, ямар учиртай байгууллага вэ? Төв байр нь хаана байдаг юм бэ?

-ФАТФ (Financial Action Task Force)-ыг Дэлхий дахинаа “Их долоо” гэж нэрлэж ирсэн орнууд 1989 онд байгуулсан юм. Тамгын газар нь Парист байдаг. Тэгэхлээр эхлээд долоон гишүүнтэй байсан гэсэн үг. Одоо түүнд 30 орон гишүүнээр нь элсээд байна. Хамгийн сүүлд Энэтхэг, БНСУ хоёр өнгөрсөн онд элссэн. Дэлхийн санхүүгийн бодлогыг тодорхойлдог, бодлогынхоо хэрэгжилтийг эргэж шалгадаг чамбай байгууллага гэж үнэлэгддэг. Энэ шалгалт үнэлгээ нь үе шаттай. Хамгийн анхныхыг нь Монгол Улсад 2007 онд хийсэн юм. Тэгэхдээ шалгалт үнэлгээг гишүүн орнуудаараа бие биед нь хийлгэдэг. Манай улсад уг үнэлгээг 2007 онд Австрали, БНСУ, Япон улсуудын болон мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх бүлгийн шинжээчид хамтран хийж өгсөн юм.

-Ийм үнэлгээ өгөхийн тулд тодорхой шалгуур үзүүлэлтүүд байна биз дээ?

-Эр нь бол ФАТФ 49 үзүүлэлтээр улс орнуудыг цэгнэдэг юм. Үүнийг нь бид Зөвлөмж гэж нэрлэдэг. 2007 онд хийсэн харилцан үнэлгээгээр манай улс



зөвлөмжийг биелүүлээгүй, тодруулбал терроризмыг санхүүжүүлэх үйлдлийг холбогдох хуульдаа гэмт хэрэг гэж үзээгүй байх, Монгол Улсын санхүүгийн

юм, Хоёрдахийг нь 2012-2013 онд хийх болов уу. Энэ хүртэлх хугацаанд манайд ахиц дэвшил гарна. Гэхдээ энэ хүртэлх завсрын хугацаанд ФАТФ бие даагаад

ажилладаггүй улс орнуудын жагсаалтыг шинэчлэн гаргахыг ФАТФ-аас шаардсан юм. Тиймээс ФАТФ Дэлхийн улс орнуудын хэмжээнд хяналт хийж